

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА ТАЙЛАН
(2023 оны эхний хагас жилийн байдлаар)**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2023.07.07

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 болон 8.1 дэх заалтыг удирдлага болгов.

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу ipeelgee.gov.mn –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэд байршсан 93 шийдвэрийн 182 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар гүйцэтгэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2023 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг хяналтад авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- Монгол Улсын 3 хуулийн 42 заалт;
- УИХ-ын 11 тогтоолын 26 заалт;
- УИХ-ын Байнгын хорооны 5 тогтоолын 9 заалт;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 4 заалт;
- Засгийн газрын 38 тогтоолын 50 заалт;
- Ерөнхий сайдын 2 захирамжийн 2 заалт;
- Засгийн газрын хуралдааны 30 тэмдэглэлийн 47 заалт;
- Засгийн газрын 1 албан даалгаврын 2 заалт **нийт 8 төрлийн 93 шийдвэрийн 182 заалтыг** хяналтад авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2023 оны эхний хагас жилийн байдлаарх хэрэгжилтийн **дундаж үнэлгээ 86.5 хувь** байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар шинээр хяналтад авсан шийдвэрүүд:

- Монгол Улсын Их Хурлын 7 тогтоолын 17 заалт;
- Улсын Их Хурлын Байнгын хорооны 2 тогтоолын 6 заалт;
- Ерөнхий сайдын 2 захирамжийн 2 заалт;
- Засгийн газрын 14 тогтоолын 14 заалт;
- Засгийн газрын хуралдааны 10 тэмдэглэлийн 16 заалт;
- Засгийн газрын 1 албан даалгаврын 2 заалт **нийт 6 төрлийн 36 шийдвэрийн 57 заалтыг шинээр** хяналтад авсан байна.

2022 оны жилийн эцсийн тайлангийн үр дүнгээр:

- Монгол Улсын 2 хуулийн 7 заалт;
- Улсын Их Хурлын 3 тогтоолын 6 заалт;

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалт;
- Засгийн газрын 7 тогтоолын 7 заалт;
- Засгийн газрын 10 хуралдааны 12 заалт **нийт 5 төрлийн 23 шийдвэрийн 34 заалтын хэрэгжилт** зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авч, холбогдох байгууллагууд хяналтдаа авсан, үр дүн гарч, тогтмолжсон шийдвэрүүдийн хасах саналыг хүргүүлснээр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаас хас ч, дотоод хяналтдаа авахыг чиглэл болгосон байна.

Гурав. Дүгнэлт

2023 оны эхний хагас жилийн байдлаар 8 төрлийн 93 шийдвэрийн 182 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг **86.5 хувиар** ханган ажилласан байна. Нийт 4 төрлийн 32 шийдвэрийн 41 заалтыг тэмдэглэгээ хийж, хяналтаас хасуулах саналыг хүргүүлж байна.

Манай байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй, дээд байгууллагын шийдвэр гарсан, цаг хугацааны хувьд дахин хэлэлцэгдэж шийдвэр гарах боломжгүй заалтуудыг **“хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”** тэмдэглэгээ хийж хяналтаас хасуулах саналын хамт хүргүүлсэн болно.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/

- 2023 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтээр удаашралтай байгаа арга хэмжээг зохион байгуулалтын арга хэмжээ авч, эрчимжүүлэх;
- <https://new.unelgee.gov.mn>-нд тайлангийн хэрэгжилтийг зөвхөн 2000 тэмдэгтэд багтаан оруулдаг тул процессыг дурьдахгүй гарсан үр дүнг тайлагнаж байх.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Н.ГАНБОЛД

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН  Д.ЦЭРЭНЛХАМ

ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (нэр төрлөөр)

(2023 оны жилийн эцсийн байдлаар)

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

2023.07.07

Улаанбаатар хот

Д/д	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл	Шийдвэрийн тоо	Хэрэгжилтийг тооцсон заалтын тоо	Үүнээс:					Хэрэгжилтийн явцын дүн (хувиар)
				Бүрэн хэрэгжсэн (100%)	Хэрэгжих шатанд (70%)	Хэрэгжилт хангалтгүй (30%)	Хэрэгжээгүй (0%)	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ)	
1	Монгол Улсын хууль	3	42	38	-	-	-	4	100.0%
2	УИХ-ын тогтоол	11	26	12	6	-	1	7	85.26%
3	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	5	9	1	8	-	-	-	73.33%
4	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг	3	4	2	1	-	-	1	90.0%
5	Ерөнхий сайдын захирамж	2	2	2	-	-	-	-	100.0%
6	Засгийн газрын тогтоол	38	50	24	19	2	-	5	84.22%
7	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	30	47	20	19	2	2	4	78.84%
8	Засгийн газрын албан даалгавар	1	2	2	-	-	-	-	100.0%
Хэрэгжилтийн дүн (шийдвэр, заалтын тоо)		93	182	101	53	4	3	21	86.52%

-----000-----